

УЛС ТӨР, ҮЗЭЛ СУРТАЛ

Ц. Хандсүрэн

**«ЛИНЬ БЯО, ЗЯН ЦИНЫ БҮЛЭГ»-ИЙГ
ШҮҮСЭН НЬ**

Хятадад Маог үхсэнээс хойш сар ч болоогүй байхад баривчилсан Маогийн бэлбэсэн гэргий Зян Цин болон ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн Ван Хунвэнь, Жан Чуньцяо, Яо Вэньюань нарыг «дөрвийн бүлэг» гэж зарлан БНХАУ-ын улс төрийн тайзнаас зайлуулаад «дөрвийн бүлгийг» илчлэн шүүмжлэх өргөн кампани 1976 оны аравдугаар сараас эхлэн хятад орон даяар өрнөж 1977 оны наймдугаар сард хуралдсан ХКН-ын XI их хурлаар «дөрвөн бүлгийг» «бут ниргэсэн» гэсэн XI их хурлын заалтын дагуу 1978 оны тавдугаар сар хүртэл үргэлжлэхдээ «дөрвийн бүлгийнхээ» л хүрээнд яригдаж байв.

Гэтэл 1978 оны тавдугаар сарын 18-ны өдөр «Жэньминь жибао» сонин «..дөрвийн бүлэг» ба Линь Бяо» гэдэг гарчигтай өгүүллийг нийтлүүлжээ. Шэн Таошэн гэдэг зохиогчтой тэрхүү өгүүлэлд: Линь Бяо-гийн «улсын даргыг бий болгох» гэсэн программ хийгээд «дөрвийн бүлгийн» дэвшүүлж байсан «хуучин кадр бол ардчилсан бүлэг, ардчилсан бүлэг нь даруй капиталист замаар замнагчид» гэсэн хөтөлбөр нь цөм нам төрийн дээд эрхийг булаан авахын тулд гаргаж ирсэн хувьсгалын эсрэг улс төрийн программ юм.¹ гэж тэмдэглэжээ.

Өгүүлэл нийтлүүлснээс хойш 10 хоноод мөн сарын 29-ны өдөр Бээжинд хятадын армийн улс төрийн ажилтны зөвлөлгөөн болж түүнд Хуа Гофэн хэлсэн үгэндээ: «Линь Бяо, дөрвийн бүлэгтэй хийсэн тэмцэлд манай армийн улс төрийн ажлын сайхан уламжлалыг бүх талаар дүгнэж өглөө» гэж анх удаагаа Линь Бяог дөрвийн бүлэгтэй холбон цааш нь хэлэхдээ «...Бид удаа дараалан Лю Шаоци, Линь Бяо, «дөрвийн бүлэг»-ийн капиталист гурван штабыг бут цохисон нь манай намын түүхэнд гурван чухал чиг шугамын тэмцэлд олсон ялалт юм»² гэжээ. Мөнхүү зөвлөлгөөнд Хуа Гофэн болон Дэн Сяопин нар хоёрдохи удаагаа оролцож Дэн Сяопин хэлсэн үгэндээ: «...одоо болон үүнээс хойш хэсэг хугацаанд «дөрвийн бүлгийг» гүнзгийрүүлэн илчлэн шүүмжлэхдээ Линь Бяотой уялдуулан шүүмжилж, тэдний хор нөлөөг цэвэрлэх хэрэгтэй»³ гэжээ.

Ийнхүү тэр цагаас эхлэн хятадын сонин, сэтгүүлд Линь Бяог дөрвийн бүлэгтэй хамт бичдэг болсон юм.

Дээр дурдсан хятадын армийн улс төрийн ажилтны зөвлөлгөөн үеэр Хуа Гофэн, Дэн Сяопин хоёрын хэлсэн үг ч хоорондоо зөрөөтэй байлаа. Хуа Гофэн «Лю Шаоциг бут цохисон явдал бол аугаа их ялалт боллоо» гэж тэмдэглэж байхад Дэн Сяодин хэлсэн үгэндээ Лю Шаониг огт дурдаагүй харин «Линь Бяо, дөрвийн бүлгийн» хор нөлөөнд автсан хүмүүсийг цэвэрлэх хэрэгтэй» гэж уриалсан билээ.

¹«Жэньминь жибао» 1978 оны тавдугаар сарын 18.

²«Жэньминь жибао» 1978 оны зургадугаар сарын 4.

³«Жэньминь жибао» 1978 оны зургадугаар сарын 3.

Тус зөвлөлгөөнөөс хойш хятадад «дөрвийн бүлгийн хор нөлөөнд автагдсан хүмүүсийг цэвэрлэх» кампани өрнөж энэ цэвэрлэгээний нэрийдлээр асар богино хугацаанд Дэн Сяопин өөрийн талын хүмүүсийг гарган ирж өөрийнхөө байр суурийг бэхжүүлж амжсан юм. Түүнээс хойш хоёр жил өнгөрсний дараа 1980 оны наймдугаар сарын эцэс есдүгээр сарын эхээр хуралдсан БХАТХ-ийн 5 дахь удаагийн сонгуулийн гуравдугаар чуулганд Хуа Гофэн есдүгээр сарын 7-нд үг хэлэхдээ: «Хувьсгалын эсрэг Линь Бяо, Зян Циний хоёр бүлэг»⁴ гэдэг шинэ томъёоллыг гаргаж ирэв. Үүнээс хойш, «дөрвийн бүлэг» гэдэг үг хятадын сонинд цөөрч түүний оронд «Линь Бяо, Зян Циний бүлэг» гэдэг хэллэг бий болов. Тухайн үед «дөрвийн бүлгийн» хэргийг тус чуулган төгссөний маргаашаас эхлэн олон нийтийн шүүхээр шүүн таслана гэдэг мэдээ тарж чуулган дуусангуут шүүх ажлын эхлэлтэнд хүмүүсийн анхаарлыг хандуулж байлаа. Мөн тэр үед «Жэньминь жибао» сонинд ч «хувьсгалын эсэргүү Линь Бяо, Зян Циний бүлэглэлийн гол хэрэгтэн удахгүй шүүгдэх болов»⁵ гэсэн гарчиг бүхий өгүүлэл нийтэлсээр байв. Гэтэл чуулганы дараа шүүх ажил эхлээгүй хойшлуулагдав. БНХАУ-ын прокурор Хуан Хуо-чин хэлэхдээ: «...Хувьсгалын эсэргүү Линь Бяо, Зян Циний хоёр бүлэглэлийг нэг хэрэг болгохоор шийдвэрлэв. Учир нь Линь Бяо, Зян Циний бүлэг нь харилцан сүлбэлдэж, харилцан бие биеэ ашиглан «Соёлын хувьсгал»-аас 5 жилийн өмнө тэд холболдон сүлбэлдэж, нам төрийн эрхийг булаан авч улсад гай, ардад зовлон авчрах ялт хэрэг үйлдэж, тэдний хийсэн ялт хэрэг нь салгаж болохгүй холбоо сүлбээтэй юм.»⁶ гэж мэдэгдэж байлаа.

Ийнхүү «дөрвийн бүлэг» гэгч нь яв явсаар «Линь Бяо, Зян Циний бүлэг» болон хувирсан билээ.

Хятадад «Линь Бяо, Зян Циний» хэргийг шүүн таслах тухай зарласнаас хойш нилээд хэдэн сар өнгөрсний дараа 1980 оны арван нэгдүгээр сарын 20-нд шүүх хурал ажлаа эхэлсэн юм. Шүүх ажил эхлэхээс урьд ардын прокурорын газрын дэргэд прокурорын «онцгой хоёр танхим» гэгчийг байгуулан ажиллуулжээ. Хурлын үед нэгдүгээр танхимд Зян Циний бүлгийнхнийг, хоёрдугаар танхимд Чэн Бода болон цэргийн бусад дарга нарын зэрэг 6 хүнийг байцаан шүүх ажлыг тус тус эрхлэн явуулав. Шүүх ажил эхлэхээс гурван хоногийн өмнө 1980 оны арван нэгдүгээр сарын 16-ны «Жэньминь жибао» сонинд гэмт хэрэгтнүүдийн ялын төлөвлөгөөг нийтлэв. Ялын төлөвлөгөөнд зааснаар хэргийн гол ялтан 16 хүн байснаас эдүгээ 6 хүн нь нэгэнт нас нөгчсөн учир Хятадын эрүүгийн хуулийн 11-р зүйлийн 5-д заасанчлан хэргийг дахин авч хэлэлцүүлэхгүй⁷ гэжээ. Мөнхүү ялын төлөвлөгөөнд: «Линь Бяо, Зян Цин нарын бүлэг нь 48 зүйл бүхий 4 том ял үйлдсэн» гэж тэмдэглэжээ. «Хувьсгалын эсрэг Линь Бяо, Зян Циний бүлэг нь «Соёлын хувьсгалын» үед өөр хоорондоо сүлбээлдэн хоршиж, зальхай муу аргаар нам, засгийн удирдагчдыг гүтгэн гүжирдэж, нам, төрийн дээд эрхийг булаан авахыг санаархан хуйвалдаан зохиож байсан» гэжээ.

Ялын төлөвлөгөөнд тэмдэглэсээ 4 том ялын Нэгдүгээрт: «Нам, төрийн удирдагчдыг гүжирдэн, пролетарийн диктатурт засгийг түлхэн унагаахыг төлөвлөж байсан» үүнд БНХАУ-ын дарга агсан Лю Шаоци, Төрийн зөвлөлийн ерөнхий сайд агсан Жоу Эньлай, БХАТХ-ын байнгын хорооны дарга агсан Жү Дэ, мөн Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн

⁴ «Жэньминь жибао» 1980 оны есдүгээр сарын 15.

⁵ «Жэньминь жибао» 1980 оны есдүгээр сарын 28.

⁶ Мөн тэнд

⁷ «Жэньминь жибао» 1980 оны арван нэгдүгээр сарын 16.

дарга, ерөнхий сайдын орлогч Дэн Сяопин болон нам дөрийн бусад удирдагчдыг гүжирдэн хорлосон ялтай» гэжээ.

Дээр дурдсан нэр бүхий хүмүүсийн дотроос одоо амьд байгаа нь зөвхөн Дэн Сяопин ажээ. Дашрамд хэлэхэд Хятадын удирдагчдаас хамгийн ихээр тамлуулж нас барсан хүн бол Лю Шаоци юм. 1967 оны долдугаар сард Лю Шаоци болон түүний гэргий Ван Гуанмэйг баривчлан шоронд хийж, «Лю Шаоци, Ван Гуанмэйгийн «онц хэргийн групп» гэгч хэргээр тэднийг хатуу хэрцгий шүүн тамлах ажлыг Зян Цин өөрийн биеэр шууд удирдаж, Кан Шэн, Чэн Бода нар оролцож байсан тухай хятадын сонинд бичсэн байна.

Лю Шаоциг шоронд хорьж тамлаж байсан тухай түүний охин ярихдаа: «Түүнийг хүний ёсноос гадуур туйлын харгис тамлаж байсны улмаас гар, хөл хоёр нь өөрийн мэдээгүй болж, тамхиа ч асааж чадахгүй байлаа. Ариун цэврийн наад захын хангамж түүнд байгаагүй. Түүнийг хүнд өвчтэй байхад нь хувцсыг нь тайчин цэрэг одеялд ороож Хэнань мужид аваачсаны улмаас уушигны хатгаа болж нас барсан юм»⁸ гэжээ.

Маршал Жү Дэгийн талаар ялын төлөвлөгөөнд тэмдэглэснийг үзэхэд түүнийг «дөрвийн бүлэг», «хятад дахь марксист-ленинист коммунист нам» гэгч болон «ХКН-ын онцгой комисс» гэгчдэд нэр холбогдуулж улмаар Жү Дэ, Чэнь И, Ли Фүчунь, Дун Биү, Е Зяньин, Ли Сянькян, Хэ Лун нарын зэрэг хүмүүсийг «гадаадтай сүлбээлдэн, зэвсэгт бослого гаргаж, төрийн эргэлт хийхийг завдсан» гэдэг нэрийдлээр тэдний түшиг болох хүмүүсийг олж илчлэхээр Чэнь И, Пэн Дэхуай, Хэ Лун нарын зэрэг нэм, төрийн олон удирдагчдыг хэлмэгдүүлж, хорлосон ялтай гэжээ. Нам, төрийн удирдагчдаас хэлмэгдсэн хүмүүсийн тоог ялын төлөвлөгөөнд дурдахдаа: Төв Хорооны гишүүн, орлогч 88 хүн, ХКН-ын VIII их хүрлын шалган байцаах комиссын гишүүн, орлогч 37 хүн, мөн БХАТХ-ын гуравдахь удаагийн сонгуулийн чуулганы байнгын хорооны гишүүн 60 хүн, дөрөвдэх удаагийн улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Байнгын хорооны гишүүдээс 74 хүнийг тус тус гүтгэн хэлмэгдүүлсэн гэжээ.

Хоёрдугаар том ял гэвэл: «Өргөн олон кадр боловсон хүчин хийгээд үй олон хөдөлмөрчдийг дарангуйлан хорлосон» гэжээ. Энэ нь Бээжин, Шанхайд хилс хэрэгт хүмүүсийг хэлмэгдүүлсэн», «Гоминьдан ба коммунистуудын хамтарсан нам» гэдэг хэргээр 84000 хөдөлмөрчдийг хэлмэгдүүлж, үүнээс 2955 хүн амь үрэгдсэн, мөн «Юньнань муж дахь гоминьданы тагнуулын бүлэг» гэдэг хэргээр 14000 гаруй хүн амь үрэгдсэн, «Нэйжэньдан» (Өвөр Монголын ардын нам) гэдэг хэргээр 346000 гаруй кадр боловсон хүчин болон хөдөлмөрчдийг гүтгэн хэлмэгдүүлж, 16222 хүн үхсэн гэжээ. Синьзянд, дайсанд бууж өгч урвасан «урвагч бүлэглэл» гэдэг хэргээр 92 хүнийг хэлмэгдүүлж 26 хүн амь үрэгдсэн бай- на. Хятадын армийн дотор олон тооны хилс хэрэг зохион 80 мянга гаруй хүнийг хэлмэгдүүлж 169 хүн амь үрэгдсэний зэрэгцээ нам, улс, олон нийтийн байгууллагуудын олон тооны боловсон хүчин хийгээд улсдаа буцаж ирээд ажиллаж байсан «Хуацяо» (цагаач иргэд) зэрэг үй олон хүнийг эрэмдэг зэрэмдэг болгон амь насыг нь бүрэлгэсэн ялтай гэжээ.

Ялын төлөвлөгөөнд заасан гуравдугаар том ял нь «Мао даргыг хорлож, хувьсгалын эсрэг зэвсэгт бослого гаргахыг завдсан» гэжээ. Энэ нь Линь Бяогийн «объект-571» буюу нэг үгээр хэлэхэд Линь Бяо зэвсэгт бослого гаргахыг завдан Гуанжоуд тусдаа намын төв хороо байгуулж, Зөвлөлттэй холбоо баигуулж, Хятадыг урьд хойноос нь хавчин довтлохыг санаархсан. Энэхүү нууц нь Жоу Эньлайд мэдэгдсэн гэдгийг ойлгонгуут 1971 оны есдүгээр сарын 13-ны өдөр гадагш зугтан одоходоо Монголын

⁸«Жаньвань» сэтгүүл. Гонгконг. 1980. № 4, 8-р тал.

Өндөрханд онгоц нь сүйрэн унажээ»⁹ гэсэн байна. Хятадын албан ёсны мэдээнд Линь Бяог Зөвлөлт руу зугтах гэж байгаад онгоцны ослоос нас барсан гэж зарласан боловч Линь Бяогийн хувь заяаны талаар янз бүрийн таамаг байсаар байна. Линь Бяог Бэйдахэ дахь байрандаа хүний гарт алагдсан гэдэг мэдээ ч байдаг.¹⁰ Шүүх хурлын дүнгээс ажиглахад дээр дурдсан «Мао даргыг хорлохыг завдан, хувьсгалын эсрэг зэвсэгт бослого гаргахыг төлөвлөж байсан» гэдэг хэргийг хамгийн хүнд ял болгожээ. Үүнээс үзэхэд Линь Бяог хамгийн хүнд ялтай этгээд мэт дүрслэн, дөрвөн том ял дотор Линь Бяогийн хэрэг»-ийг хамгийн ноцтой болгон товойлгож, үүгээрээ хятадын ард түмний анхаарлыг «Линь Бяогийн хэрэг рүү хандуулахыг оролдсон нь илт байна. Ялын төлөвлөгөөнд заасан дөрөвдүгээр том ял нь «Шанхайт зэвсэгт бослого гаргахыг завдсан гэгч хэрэг болно. Уул хэрэг явдал 1976 оны аравдугаар сарын 8-ны өдөр Шанхан дахь «дөрвийн бүлгийнхэн» Зян Цин нарыг баривчилсан тухай нууц мэдээ авануут түргэн жагсаал авч 33500 өрхийн цэргийг зохион байгуулж, зэвсэгт бослого гаргахаар 27000 гаруй буу зэвсэг, 225 авто машин, их хэмжээний эд материал, хоол хүнс, холбооны 15 цэг, зохицуулах гурван газар нууц дохио өгөх хоёр төв байгуулан «Шанхай хот болон бүх улсын ард түмэнд мэдэгдэх бичиг» тараахаар завдаж балсны дээр тус хотын үйлдвэрийг зогсоох, ажил хаялт зохион байгуулах, сүрт жагсаал хийлгэх, сонин, хэвлэл радио мэдээллийг гартаа авч төвийн мэдээ нэвтрүүлгийг таслах, түүнчилэн усан боомт, нисэх онгоцны буудлыг бүслэх зэрэг ажил зохиохоор төлөвлөж байсан ялтай»¹¹ гэсэн байна.

Энэ мэтчилэнгээр хятадад 4 жилийн тэртээ 1976 онд баривчлагдсан «Дөрвөн дэрэмчин»-г 1980 оны арван нэгдүгээр сараас эхлэн шүүж, тэдний үйлдсэн ялыг нийтийн өмнө дэлгэн гаргаж тавьсан нь хэдийгээр хятадын одоогийн удирдагчид хамаг муу муухай хэргийн эзэн Мао Зэдунийг гэмт хэрэг үйлдээгүй, харин алдаа хийсэн мэт хуурамч нотолгоогоор халхавчлан Маогийн бодлогыг тугаа болгон үлдээхийг оролдсоор байгаа боловч маоизмын харгис мөн чанарыг илчилж, тэднээс төрийн эрхийн төлөө тэмцэлдэж байгааг тэд томруун харуулж байна. Уг шүүх ажиллагааны явцад Зян Цин хэргээ огт хүлээхгүй байсаар эцсийн ялаа сонсов. Нөгөө талаар Зян Цин, Линь Бяотой нягт холбоо, сүлбээтэй гэдэг зэмлэгийг үгүйсгэн эсэргүүцэж харин ч Линь Бяогийн эсрэг тэмцэж байсан гэж өчив. Зян Циний энэхүү өчиг нь шүүх хуралдааны зохион байгуулагчдад таалагдсангүй учир түүнийг шүүх хурлын танхимаас хүчээр гаргах, мөн Зян Цинтэй Линь Бяогийн утсаар ярьсан яриагаар нотлохыг оролдох зэрэг явууллага хийж байв. Хятадад явагдсан шүүх хурлын талаар гадаадын хэвлэлд бичихдээ шүүхийн жүжиг хэмээн бичиж байна. Үнэн хэрэг дээр ч тийм байгаа юм.

Энэ нь Бээжингийн эрх баригчдын төрийн эрхийн төлөөний тэмцэлдээний бас нэг хэлбэр бөгөөд, шүүх хурал болгон жүжиглэсэн театрийн нэгэн үзэгдэл төдий болсон байна. Юу гэвэл шүүх хурлыг зохион байгуулагчид урьд нь хоёр гурван удаа сургууль хийж тэндээс хэрэгтнүүдээс гэрч этгээдэд чухам хэрхэн хандахыг судалж байсан бололтой. Үүний үр дүнд гэмт хэрэг үйлдсэн үйл анги нь цөөрсөн байна. Прокурорын нэгдүгээр танхимд шүүгдэж байсан Ван Хунвэнь «дөрвийн бүлгийн» дотор хамгийн залуу болохоор хуучин хамсаатангаа «өнгөрсөн хорвоо» гэж үзээд өөрийн үйлдсэн ялыг бүрэн хүлээсэн байна. Гэвч «дөрвийн бүлгийн» хэргийг байцаах тусам Мао болон Хуа Гофэн, Ван Дунсин нар хол-

⁹ «Жэньминь жибао» сонин. 1980 оны есдүгээр сарын 16.

¹⁰ «Синьдао сонин» 1980 оны арван нэгдүгээр сарын 8.

¹¹ «Жэньминь жибао» 1980 оны арван нэгдүгээр сарын 16.

богдох нь ихсэж байв. Жишээ нь: 1980 оны арван хоёрдугаар сарын 5-ны өдөр Зян Цинг байцаах үеийн асуулт, хариултын заримыг дор сийрүүлбээс: Зян Цин өчихдөө, «соёлын хувьсгалын» үед би нам болон Мао даргаас өгсөн даалгаварыг л биелүүлж байсан юм. Дөрвөн хуучныг эвдэх, хүмүүсийн гэрт нэгжилт хийх, зодож жанчих явдал бол цөм хувьсгалт үйл ажиллагаа байснаас биш миний үйлдсэн ялт хэргийн гэрч баримт биш» гэжээ. Шүүгчээс: «Чи хуулийг зөрчсөн» гэхэд Зян Цин: Тухайн үед би хууль ёсны дагуу л хийж байсан» гэв. Шүүгч: «Чи үндсэн хуулийг зөрчиж байна» гэхэд Зян Цин «Энэ бол чиний одоогийн хуулийг л зөрчиж байгаа хэрэг юм». Шүүгч: «Чи хэргийнхээ хариуцлагыг Мао даргад оногдуулах гэж дэмий юм чалчиж байна» гэхэд Зян Цин: «Тийм биш. Би тухайн үед Мао даргын удирдлагын дор хувьсгал хийж байна гэдэг санаагаар л бүх юмыг хийж байсан юм»¹² Ингэхэд нь Зян Цинийг цааш ярихыг шүүгч зогсоож байв. Шүүх хурлын үед Зян Цин, Хуа Гофэнтэй нүүрэлдүүлж өгөхийг хүсч нохойг зодохдоо ч гэсэн түүний эзэн нь хэн гэдгийг бодох хэрэгтэй» гэж байсан юм. Шүүх ажиллагаа ийм байдлаар явагдаж байв. Арван гол ялтныг шүүх ажиллагааг гадаад дотоодод телевизээр нэвтрүүлнэ гэж урьдчилан ихээхэн зарласан боловч шүүх явц болон асуулт, хариултыг «улсын нууцтай» холбоотой гэдэг шалтгаанаар бүрэн гүйцэд харуулаагүй, зөвхөн цухас нэвтрүүлсэн билээ. Прокурорын онцгой танхим, шүүгдэж буй 10 гол ялтанд оногдуулах ялыг дор нь шийдэж чадаагүй ба хоёр сар 5 хоног болсны дараа буюу 1981 оны нэгдүгээр сарын 25-ны өдөр эцсийн тогтоол гаргаж, дээр дурдсан арван гол ялтны дотроос Зян Цин Жан Чуньцяо хоёрт алах ял оноогоод тогтоолыг хоёр жилийн дотор гүйцэтгэхээр шийдвэрлэв. Мөн Ван Хунвэньд бүх насаар нь хорих ял оноогоод эдгээр гурван хүний улс төрийн эрхийг бүх насаар нь хасчээ. Үлдсэн долоон хүн, тухайлбал: Яо Вэньюанийг 20 жилээр, Чэн Бода, Хуан Юншэнь, Зян Тэняо нарыг 18 жилээр, Ү Фасянь, Ли Зопэн нарыг 17 жилээр, Чю Хуйзод 16 жилээр хорих ял тус тус оноожээ. Эдгээр хүмүүсийн улс төрийн эрхийг 5 жилээр хассан байна. Ийнхүү шүүх ажиллагаа гүнзгийрэх тутам Маогийн гэм буруу улам их болж, Маог «дөрвийн бүл- гийнхнээс ялган тусгаарлаж, түүний нэр хүндийг цэвэр үлдээх гэсэн эрмэлзлэл ч биелэгдэхгүйд хүрч байв. Ялын тогтоолыг уншин сонсох үеэр Зян Цин «соёлын хувьсгал» гэгчийн үеийн лоозон хашгирч шүүхийн гишүүдийг «ревизионистууд» гэж нэрлэсэн учир түүнийг шүүхийн танхимаас хүчээр гаргажээ. Шүүх ажиллагаа нь ХКН-ын XII их хурлын бэлтгэлд зориулагдан, хятадын удирдагчдын хоорондох нам, төрийн эрхийн төлөө тэмцэлдээний нэгэн талбар болов. Эдүгээ хятадын ард түмэн Бээжингийн албан ёсны шийдвэрт итгэхэд бэрхтэй болж харин тэдэнд «Соёлын хувьсгалын» үеийн зэрлэг хэрцгий харилцаа адал балмад үйлдлийн үргэлжлэл мэт санагдах нь их болжээ. Учир нь тухайн үеийн бүхий л сонин хэвлэлд Маогийн зааврыг тасралтгүй хэвлүүлж байсан бөгөөд тэдгээр заавруудын заалтууд ч тоосгон хананд «Дазы бао» хуудсуудаар наагдаж байсан нь тодхон билээ.

Маогийн хойчийг залгамжлагчид «Соёлын хувьсгалаар» гарсан бүхий л адал балмад үйл явдлыг «дөрвийн бүлэгт» тохоод, Маог цэвэр үлдээх зорилтоор, «дөрвийн бүлгийг» шүүх хурлыг урдаас боловсруулсан төлөвлөгөөтэй явуулсан боловч тэр нь амжилт олоогүй юм.

Шүүх хурлын дүнгээс үзвэл бүх бурууг зөвхөн «дөрвийн бүлэг»-т тохож болохгүй байв. Бүх зүйл Маогийн удирдлагаар шийдвэрлэгдэж байсан нь Маогийн бэлбэсэн гэргий Зян Циний өчгөөс тодорхой болсон юм. Тиймээс шүүх хурал «дөрвийн бүлгийн» хэргийг цааш нь үргэлжлүүлээд байх юм бол Хуа Гофэн зэрэг удирдах хүмүүсийн нэр хүндэд улам муу-

¹²«Жаньвань» сэтгүүл. Гонконг, 1980. 12. 16. 5 дахь тал.

гаар нөлөөлөх хандлагатай болсон учир шүүх хурлыг даруй хаажээ. Мөн цаазаар авах ял оноосон хоёр хүний шийтгэлийг гүйцэтгэх хугацааг хоёр жилээр тогтоосны жинхэнэ учир шалтгаан чухам юунд оршиж байгааг таамаглахад ч бас төвөггүй байна. Шүүх хурал Маогийн «онцгой курс» гэгчийн дампуурал, маоизм бүхэлдээ хятадын ард түмэнд хичнээн их ган гамшиг учруулсныг гэрчиллээ.

Шүүх хурлын явц хятадад улс төрийн байдал тогтворгүй хийгээд ХКН-ын XII их хурлын өмнөх засгийн эрхийн төлөө тэмцлийн хурцдал, дотоодын улс төрийн бодлогын дампуурал болон ирээдүйдээ итгэхгүй явдал их байгааг дахин баттай харуулав.¹³ Гэвч хятадын удирдагчдын тавьж буй олон үзэгдэлт бээжин «жүжиг» үүгээр дуусаагүй байна.

1980 оны арван нэгдүгээр сарын 20-нд шүүх хурал нээснээс хойш хятадад «Линь Бяо, Зян Циний хэрэгт» холбогдох нам, төр болон армийн 60 хүний нэрийг нийтэлсэн юм. Шүүх байгууллага нь эдгээр хүмүүсээр үл барам улам олон хүнийг Линь Бяо, Зян Цин нарын хамсаатан болгохыг эрмэлзэж байна.

Японы «Исмиүри» сонин 1980 оны арван хоёрдугаар сарын 20-ны дугаараа «...ХКН 1981 оныг намын доторхи их цэвэрлэгээний он» болгох гэж байгаа тухай Бээжинд суугаа сурвалжлагчийнхаа мэдээг үндэслэн нийтлэв. ХКН-ын мэдээлснээр энэ цэвэрлэгээ нь намын түүхэнд хийх мэс засал болох юм. Намын 38 сая гишүүдээс 20%-ийг цэвэрлэх болно гэж дээрх сонин мэдэгджээ. Түүгээр барахгүй тэн хагасыг нь хүртэл цэвэрлэж удаан үргэлжилж магадгүй гэсэн таамаг ч бий. ХКН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын газрын гишүүн, Нийгмийн ухааны академийн ерөнхийлөгч Хү Цяому-гийн тавьсан хаалттай илтгэлээс иш татаж Английн «Файнэншл таймс» сонин бичихдээ ХКН-ын доторхи энэ удаагийн цэвэрлэгээ 1981 оноос 1983 он хүртэл гурван жил үргэлжилнэ» гэжээ.

«Дөрвийн бүлгийн» хэргийг шүүсний дараагаар хятадын орон нутаг (мужуудад) мөн ийнхүү шүүх ажиллагааг эхлэн явуулж байгаа бөгөөд цаашид нам, төр, олон нийтийн байгууллагууд, армийн дотор өргөн цэвэрлэгээ хийх ажлыг нилээд удаан хугацаагаар өрнүүлэх гэж байгаагаа хятадын удирдагчид нуухгүй ярьж, сонин хэвлэлд илт бичиж байна.

Эцэст нь нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд «дөрвийн бүлэгт» оноосон 48 зүйл бүхий 4 том ялын дотор хятад бус үндэстнүүдийг улс төр нийгэм-эдийн засаг, соёл ба бусад талаар хэлмэгдүүлж байсан тухай ганц ч үг дурдалгүй өнгөрчээ. Энэ нь чухамдаа хятадын өнөөгийн эрх баригчид маогийн их хан үндэстний дээрэнгүй, уусган хайлуулах бодлогыг цаашид үргэлжлүүлнэ гэсэн хэрэг даруй мөн билээ.

Ц. Хандсүрэн

СУД НАД ЛИНЬ БЯО И «БАНДОЙ ЦЗЯН ЦИН»

Свою статью автор посвящает судебному процессу по разбирательству дела «банды четырёх», и показывает, что этот «спектакль» с самого начала был подготовлен и неоднократно репетировался. пока не был поставлен.

¹³ «Правда» сонин 1981 оны нэгдүгээр сарын 28.

Наконец, 20 апреля 1980 г. он начался в специально созданных по этому случаю двух палатах: первой-для разбирательства дел группы Цзян Цин, второй для остальных обвиняемых. Из 4-х крупных обвинений, состоящих из 48 пунктов, предъявленных «банде четырех», «дело по попытке покушения на Мао» выделялось особой статьей, и китайская печать обращала своё внимание на «дело Линь Бяо», который по обвинениям предъявленным на суде, был причастен к попытке покушения на Мао.

Из показаний вдовы Мао стало ясно, что она «лишь выполняла указания Мао Цзэдука» Подобное заявление, отмечает автор, скомпрометировало не только Мао, но и некоторых нынешних руководителей, находившихся в его окружении, в том числе и Хуа Гофэна, что заставило их срочным образом закрыть заседание суда.

Суд над «бандой четырех» по сути является еще одним проявлением непрекращающейся борьбы за власть, которая обострилась накануне XII съезда КПК среди различных группировок китайского руководства. Исходя из этого, автор делает вывод, что Китай стоит на пороге очередной широкой кампании по чистке партийных, кадровых работников которая вот-вот развернется по всей стране, о чем открыто пишет китайская печать.

В заключение подчеркивается, что среди всех обвинений, выдвинутых «банде четырех», ни слова не упоминается о преступной деятельности, проводившейся ими по отношению к неханьским национальностям. Это является признаком того, что нынешние китайские руководители по-прежнему продолжают великоханьский курс, проводимый по отношению к ттекитайским национальностям.